

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11. Шилэн дансны мэдээлэл	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал.....	11
3.1. Санхүүгийн програм хангамжийн талаар	11
3.2. Бэлэн мөнгөний үлдэгдлийн талаар	11
3.3. Хувь хүний орлогын албан татварын талаар	12
3.4. Нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн ногдуулалт, алдангийн талаар	12
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4. Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
4.6. Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	25
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Ч.ЧИМЭДРАГЧАА ТАНАА

2019.02.25 № 06/315
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн захирал Ч.Чимэдрагчаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн мөнгөн хөрөнгө, татвар шимтгэлийн тооцоолол, санхүүгийн программ хангамжийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 27-ноос 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Эф Эл Эй Эс Эйч аудит” ХХК-ийн аудитор Б Баяндүүрэн, аудиторын туслах Г.Цэнд-Аюуш нар хариуцаж хэрэгжүүлэв.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эф Эл Эй Эс Эйч аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн хамт олон нотолгоонд суурилсан эмчилгээ, үйлчилгээ үзүүлж, эрдэм шинжилгээ, эмийн үйлдвэрийн ажилтнуудын мэдлэг чадвар, орчин үеийн лабораторийн дэвшилтэт технологид тулгуурлан судалгаа сорил, туршилт, үйлдвэрлэлийн арга барилд түшиглэн хэрэглэгч, үйлчлүүлэгчийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэн улам бүр хөгжүүлэх эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 тоот тогтоолоор Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажил хийх
- Уламжлалт болон орчин цагийн анагаах ухаан хосолсон эмнэлгийн үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ (стационар), уламжлалт эмийн үйлдвэр

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Инновацийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Архивын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд нийцэж байгаа боловч үйл ажиллагааны онцлогийг харгалзан сайжруулах шаардлага байна.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтнийг татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамж ашигладаг байна.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлаар сонгох нь зохимжтой гэж үзэж төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын байдлын суурийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгосон.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2018 оны нийт зардал 2,638,832.1 мянган төгрөг бөгөөд 1 хувь болох 26,388.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Эрсдэлийн түвшинг дундаж гэж үнэлэн материаллаг байдлыг суурь үзүүлэлтийг 1 хувиар тооцох нь зохимжтой гэж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй, 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож шийдвэрлэснээс 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөг/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	749.2	
	Дүн	4	749.2	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ОХУ-ын Хууль зүйн яаманд хүргүүлсэн "Новоя Азия" ХХК-тай холбогдох 38,638.1 мянган төгрөгийн авлагын эргэн төлөлт, шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл, валютын ханшийн зөрүүний асуудал болон урьдчилж төлсөн зардлын бүртгэл, инновацийн төсөл хөтөлбөрийн үр дүнг шалгах.

Тус хүрээлэн хоёр яамнаас санхүүжилт авч байгаа явдал нь үйл ажиллагааны үндсэн чиглэлд нийцэж байгаа эсэхийг анхаарч авч үзэх нь зүйтэй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 4 хөтөлбөр, 3 арга хэмжээнд зориулан 2018 онд 2,405,363.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн нь 2,348,268.9 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь тус хүрээлэн 2018 оны байдлаар улсын төсвийн санхүүжилтийг 57,095.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан. Үүнд: байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 29,805.7 мянган төгрөгөөр, багаж техник худалдаж авах зардал 10,582.7 мянган төгрөгөөр дутуу байна.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас орох орлого 426,920.5 мянган төгрөг буюу 90,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь хэвтэн эмчлүүлэгчдийн орлогын 10 хувийг нийт ор хоногийн тоогоор төлөвлөсөн нь эмчлүүлэгчдийн 63,3 хувь нь тэтгэвэр, группын хүмүүс байсан нь голлон нөлөөлсөн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээ, төсвийн орлого, зарлага, худалдан авалттай холбоотой 83 ширхэг ажил үйлчилгээний мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж байх, авлагын дансны үлдэгдийг тооцоо нийлж баталгаажуулах талаар 2 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Санхүүгийн програм хангамжийн талаар

3.1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн “асолус” програм хангамж ашиглан бэлтгэдэг байна. Програм нь эмийн үйлдвэрлэлийн өртөг, борлуулалтын модуль байхгүйгээс бүртгэлээр хяналт тавих боломжгүй байна. Тухайлбал: борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын орлогын дүнг улирлын эцэст хаалтын бичилт хийж бүртгэж байна.

3.1.2. Эрсдэл:

Өртгийг хянах боломжгүй байх, эмийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас алдагдал хүлээх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж чадахгүй байх.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлж санхүүгийн програмд сайжруулалт хийлгэх, бүртгэлийг сайжруулах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын байгууллагаас ирүүлсэн асуудлын бүртгэлээр баталгаажуулсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

3.2. Бэлэн мөнгөний үлдэгдлийн талаар

3.2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд кассад байгаа бэлэн мөнгөний үлдэгдэлд ажиглалт хийхэд бэлэн мөнгөний үлдэгдэл нь өндөр байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмын 6.2 дахь заалт Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ(ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамаарахыг мөрдөж ажиллаагүй байна.

3.2.2. Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, журам зөрчигдөх, бэлэн мөнгөний дутагдал шамшигдал үүсэх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмын 6.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Хувь хүний орлогын албан татварын талаар

3.3.1. Илрүүлэлт:

Ажилчдын цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогын татварын тайланд 6,003.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг илүү тооцсон. Үүний 10 хувь буюу 600.3 мянган төгрөгөөр хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг илүү тооцсон.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогоос нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд төлсөн шимтгэлийг хассан дүнгээр албан татвар ногдох орлогыг тодорхойлно гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

3.3.2. Эрсдэл

Холбогдох хуулийн заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллахгүй байх, татварын алданги торгууль хүлээх эрсдэлтэй .

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тайлангийн хөнгөлөлтийн тооцоог дахин хийж тайлагнах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.4. Нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн ногдуулалт, алдангийн талаар

3.4.1. Илрүүлэлт:

Ажилтны тэтгэмжтэй чөлөө авч хүүхдээ асарч байгаа хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож төлөөгүйгээс нийгмийн даатгалын улсын байцаагчийн 2018 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 385 тоот актаар 99.2 мянган төгрөгний нөхөн төлбөр, 49.6

мянган төгрөгний алдангийг төлсөн байна. Энэ нь Засгийн газрын 212 тоот тогтоолын 2-р хавсралтын 2.в-д “Хүүхдээ асрахаар тэтгэмжтэй чөлөө авсан эхийн чөлөөтэй байх хугацааны шимтгэлийг аж ахуйн нэгж, байгууллага нь Засгийн газраас тогтоон тухайн үед мөрдүүлж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар тооцож сар бүр даатгалын зохих санд төлнө” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.4.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулах.

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллах, буруутай албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 01-ний дотор хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	668,652,479.70	723,286,415.93
33	АВЛАГА	46,211,289.69	51,308,267.38
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,000.00	0.00
335	Бусад авлага	46,209,289.69	51,308,267.38
3351	Байгууллагаас авах авлага	42,867,389.69	47,978,267.38
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,341,900.00	3,330,000.00
34	УРЬДЧИЛГАА	75,030,900.00	191,750,849.00
34600	Урьдчилж гарсан зардал	75,030,900.00	182,150,849.00
3471	Урьдчилгаа тооцоо	00.00	9,600,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	00.00	9,600,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	547,410,290.01	480,227,299.55
351	Түүхий эд материал	159,633,139.91	186,229,894.84
35110	Тусгай зориулалттай материал	133,446,644.37	151,104,634.61
35130	Эм боох материал	26,186,495.54	35,125,260.23
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	42,556,093.22	3,469,267.13
35300	Бэлэн бүтээгдэхүүн	180,794,607.79	115,935,767.69
354	Хангамжийн материал	160,997,949.09	170,453,369.89
35410	Бичиг хэргийн материал	94,324,526.00	90,899,238.00
35420	Аж ахуйн материал	4,929,790.02	4,229,878.02
35430	Сэлбэг хэрэгсэл	150,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	970,169.71	433,147.71
35450	Барилгын засварын материал	20,834,244.35	22,660,894.35
35460	Хүнсний материал	8,259,610.00	16,244,180.14
35470	Бусад хангамжийн материал	31,529,609.01	35,986,031.67
35600	Мал амьтад	3,428,500.00	4,139,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,717,540,765.57	2,458,526,999.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,717,540,765.57	2,458,526,999.72
391	Газар	00.00	0.00
392	Биет хөрөнгө	1,717,256,078.19	1,865,783,539.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,473,234,092.20	1,444,208,366.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,287,259,111.10	-16,261,514.23
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,590,200.00	57,287,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-50,840,200.05	-47,787,400.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,232,971,987.91	1,252,219,281.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-783,137,283.90	-875,457,120.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	214,820,677.00	225,254,564.79
39208	Хуримтлагдсан элэгдэл	-150,876,283.87	-173,680,039.06
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,752,000.00	0.00
393	Биет бус хөрөнгө	284,687.38	592,743,460.06
39301	Програм хангамж	00.00	6,241,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-3,101,499.94
39303	Бусад биет бус хөрөнгө	5,479,000.00	591,840,960.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-5,194,312.62	-2,237,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,386,193,245.27	3,181,813,415.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	81,336,805.89	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	81,336,805.89	0.00
413	Өглөг	6,305,905.89	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,480,133.82	0.00
4136	Бусад өглөг	4,825,772.07	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,825,772.07	0.00
414	Урьдчилж орсон орлого	75,030,900.00	0.00

41440	Бусад урьдчилж орсон орлого	75,030,900.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,304,856,439.38	3,181,813,415.65
51	Засгийн газрын хувь оролцоо	2,304,856,439.38	3,181,813,415.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,285,807,733.51	2,875,411,193.51
51101	Өмч: - төрийн	2,285,807,733.51	2,875,411,193.51
51102	- хувийн	00.00	0.00
51103	- хувьцаат	00.00	0.00
51104	Халаасны хувьцаа	00.00	0.00
51105	Нэмж төлөгдсөн капитал	00.00	0.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	00.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	-281,843,987.94	-241,949,312.98
51210	Өмнөх үеийн үр дүн	-270,729,981.36	-200,848,419.46
51220	Тайлант үеийн үр дүн	-11,114,006.58	-41,100,893.52
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	300,892,693.81	548,351,535.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,386,193,245.27	3,181,813,415.65

4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,442,518,965.46	2,597,731,217.40
118101	Газрын төлбөр	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	547,174,550.41	547,493,521.40
120	Нийтлэг татварын бус орлого	547,174,550.41	547,493,521.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	547,174,550.41	547,493,521.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	461,736,872.00	426,906,678.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,966,750.00	29,378,160.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	0.00	0.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	83,470,928.41	91,208,683.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,895,344,415.05	2,050,237,696.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	557,345,654.05	575,297,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	557,345,654.05	575,297,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,146,261.00	120,736,096.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,414,430.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,539,200.00	8,897,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,192,631.00	111,838,496.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,254,852,500.00	1,354,204,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,254,852,500.00	1,354,204,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,453,632,972.04	2,621,133,809.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,453,632,972.04	2,621,133,809.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,309,573,299.02	2,568,373,375.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,131,024,003.00	1,137,613,627.00
210101	Үндсэн цалин	1,101,931,475.00	806,734,696.00
210102	Нэмэгдэл	0.00	192,474,604.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,092,528.00	77,177,048.00
210104	Урамшуулал	0.00	56,581,479.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	4,645,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,485,166.14	137,279,824.46
210201	Тэтгэврийн даатгал	122,485,166.14	93,184,703.46
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	11,023,655.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	8,819,105.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	2,204,651.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	22,047,710.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,020,686.00	113,299,449.93
210301	Гэрэл, цахилгаан	40,006,836.00	43,468,504.00
210302	Түлш, халаалт	45,095,530.00	45,831,364.00

Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	31,918,320.00	23,999,581.93
2104	Хангамж, бараа материалын зардал	70,927,411.50	73,774,407.34
210401	Бичиг хэрэг	14,406,748.00	11,292,350.00
210402	Тээвэр, шатахуун	7,709,624.93	4,969,915.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,640,742.67	9,246,093.34
210404	Ном, хэвлэл	7,345,315.00	214,410.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,130,000.00	8,933,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,025,143.00	27,025,241.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		0.00
210408	Бараа материал акталсны зардал	1,669,837.90	12,093,198.00
2105	Нормативт зардал	310,270,692.73	364,393,717.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,143,907.00	169,419,265.71
210502	Хоол, хүнс	156,995,385.73	181,948,451.86
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,131,400.00	13,026,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,472,160.00	59,834,450.00
210604	Урсгал засвар	39,472,160.00	59,834,450.00
2107	Томилолт, зочны зардал	4,180,500.00	3,892,400.00
210702	Дотоод албан томилолт	4,180,500.00	3,892,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	328,427,745.00	67,774,403.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	324,100,945.00	63,191,403.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	154,800.00	154,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00	269,400.00
210807	Газрын төлбөр	1,508,400.00	1,658,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,764,934.65	610,511,095.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,939,214.10	404,229,444.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	170,825,720.55	206,281,650.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,059,673.02	52,760,433.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,725,200.00	39,086,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,396,200.00	39,086,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,329,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,334,473.02	13,673,733.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,334,473.02	13,673,733.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-11,114,006.58	-23,402,591.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	17,698,301.91
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	0.00	17,698,301.91
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-17,698,301.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-11,114,006.58	-41,100,893.52

4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,432,543,583.00	2,481,270,774.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	464,790,422.00	431,033,078.00
120	Нийтлэг татварын бус орлого	464,790,422.00	431,033,078.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	464,790,422.00	431,033,078.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,865,672.00	426,920,578.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,924,750.00	4,112,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,967,753,161.00	2,050,237,696.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	629,754,400.00	575,297,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	629,754,400.00	575,297,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	83,146,261.00	120,736,096.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,414,430.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,539,200.00	8,897,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,192,631.00	111,838,496.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,254,852,500.00	1,354,204,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,254,852,500.00	1,354,204,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,370,314,742.98	2,420,433,194.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,370,314,742.98	2,420,433,194.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,224,284,069.96	2,367,672,760.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,096,031,966.49	1,138,879,486.27
210101	Үндсэн цалин	798,179,612.49	810,639,179.27
210102	Нэмэгдэл	212,436,600.00	183,550,120.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,153,772.00	84,129,048.00
210104	Урамшуулал	40,261,982.00	55,915,339.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	4,645,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,438,920.20	137,087,497.00
210201	Тэтгэврийн даатгал	122,438,920.20	92,992,376.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	11,023,655.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	8,819,105.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	2,204,651.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	22,047,710.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,020,686.00	113,299,449.93
210301	Гэрэл, цахилгаан	40,006,836.00	45,130,290.00
210302	Түлш, халаалт	45,095,530.00	45,831,364.00
210303	Цэвэр, бохир ус	31,918,320.00	22,337,795.93
2104	Хангамж, бараа материалын зардал	57,012,263.67	57,815,103.34
210401	Бичиг хэрэг	9,606,400.00	4,727,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,228,150.00	4,265,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,640,742.67	9,246,093.34
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,990,000.00	8,933,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,546,971.00	30,643,390.00
2105	Нормативт зардал	308,338,476.60	382,107,781.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	156,888,154.60	205,737,329.56
210502	Хоол, хүнс	145,987,837.00	164,406,552.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,462,485.00	11,963,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,643,410.00	60,705,698.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,035,100.00	574,998.00
210604	Урсгал засвар	41,608,310.00	60,130,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,064,540.00	3,892,400.00
210702	Дотоод албан томилолт	5,064,540.00	3,892,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	459,733,776.00	458,564,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	452,217,976.00	448,367,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	154,800.00	154,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00	252,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	16,800.00
210807	Газрын төлбөр	1,508,400.00	1,658,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,189,000.00	5,614,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,031.00	15,320,564.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,031.00	15,320,564.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,030,673.02	52,760,433.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,696,200.00	39,086,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,396,200.00	39,086,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,300,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,334,473.02	13,673,733.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,334,473.02	13,673,733.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	62,228,840.02	60,837,580.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	78,119,990.00	60,837,580.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,119,990.00	60,837,580.00
2200	Дотоод эх үүсвэрээр	78,119,990.00	60,837,580.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	78,119,990.00	60,837,580.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-78,119,990.00	-60,837,580.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-15,891,149.98	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,891,149.98	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

4.4. Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,285,807,733.51	300,892,693.81	-267,612,949.96	2,319,087,477.36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-3,117,031.40	-3,117,031.40
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,285,807,733.51	300,892,693.81	-270,729,981.36	2,315,970,445.96
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-11,114,006.58	-11,114,006.58
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,285,807,733.51	300,892,693.81	-281,843,987.94	2,304,856,439.38
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	80,995,568.48	80,995,568.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,285,807,733.51	300,892,693.81	-200,848,419.46	2,385,852,007.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	247,458,841.31	0.00	247,458,841.31
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	589,603,460.00	0.00	0.00	589,603,460.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-41,100,893.52	-41,100,893.52
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,411,193.51	548,351,535.12	-241,949,312.98	3,181,813,415.65

4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,405,363,200.00	2,348,268,961.50	-57,094,238.50	97.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,405,363,200.00	2,348,268,961.50	-57,094,238.50	97.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,350,954,300.00	2,293,861,697.10	-57,092,602.90	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,106,691,000.00	1,098,658,508.27	-8,032,491.73	99.3
210101	Үндсэн цалин	760,060,200.00	770,418,201.27	10,358,001.27	101.4
210102	Нэмэгдэл	182,927,100.00	183,550,120.00	623,020.00	100.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	103,745,800.00	84,129,048.00	-19,616,752.00	81.1
210104	Урамшуулал	55,312,100.00	55,915,339.00	603,239.00	101.1
210105	Гэрээт ажлын хөлс	4,645,800.00	4,645,800.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,705,200.00	132,260,980.00	-444,220.00	99.7
210201	Тэтгэврийн даатгал	88,570,200.00	88,165,859.00	-404,341.00	99.5
210202	Тэтгэмжийн даатгал	11,058,700.00	11,023,655.00	-35,045.00	99.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,747,000.00	8,819,105.00	72,105.00	100.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,211,700.00	2,204,651.00	-7,049.00	99.7
210205	Эрүүл мэндийн даатгал	22,117,600.00	22,047,710.00	-69,890.00	99.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,105,200.00	113,299,449.93	-29,805,750.07	79.2
210301	Гэрэл, цахилгаан	44,884,700.00	45,130,290.00	245,590.00	100.5
210302	Түлш, халаалт	63,917,100.00	45,831,364.00	-18,085,736.00	71.7
210303	Цэвэр, бохир ус	34,303,400.00	22,337,795.93	-11,965,604.07	65.1
2104	Хангамж, бараа материалын зардал	50,244,900.00	49,314,783.34	-930,116.66	98.1
210401	Бичиг хэрэг	3,859,600.00	3,984,600.00	125,000.00	103.2
210402	Тээвэр, шатахуун	3,766,100.00	3,712,100.00	-54,000.00	98.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,501,600.00	9,246,093.34	-1,255,506.66	88.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,429,600.00	8,933,200.00	-496,400.00	94.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,688,000.00	23,438,790.00	750,790.00	103.3

2105	Нормативт зардал	343,252,300.00	337,137,005.56	-6,115,294.44	98.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	187,027,900.00	175,220,193.56	-11,807,706.44	93.7
210502	Хоол, хүнс	144,659,000.00	149,952,912.00	5,293,912.00	103.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,565,400.00	11,963,900.00	398,500.00	103.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,580,400.00	92,906,690.00	-10,673,710.00	89.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,236,300.00	34,653,590.00	-10,582,710.00	76.6
210604	Урсгал засвар	58,344,100.00	58,253,100.00	-91,000.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	3,442,800.00	3,325,400.00	-117,400.00	96.6
210702	Дотоод албан томилолт	3,442,800.00	3,325,400.00	-117,400.00	96.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	467,932,500.00	466,958,880.00	-973,620.00	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	457,031,900.00	456,761,880.00	-270,020.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,104,000.00	2,500,000.00	-604,000.00	80.5
210803	Даатгалын үйлчилгээ	155,400.00	154,800.00	-600.00	99.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,600.00	252,600.00	00.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,800.00	16,800.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	1,658,800.00	1,658,800.00	00.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00		-99,000.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,614,000.00	5,614,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,322,200.00	15,320,564.40	-1,635.60	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,322,200.00	15,320,564.40	-1,635.60	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,086,700.00	39,086,700.00	00.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,086,700.00	39,086,700.00	00.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,405,363,600.00	2,348,268,961.50	-57,094,638.50	97.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	574,697,600.00	563,031,883.50	-11,665,716.50	98.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	574,697,600.00	563,031,883.50	-11,665,716.50	98.0

1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,354,204,000.00	1,354,204,000.00	00.00	100.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,354,204,000.00	1,354,204,000.00	00.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА С	476,462,000.00	431,033,078.00	-45,428,922.00	90.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	470,500,000.00	426,920,578.00	-43,579,422.00	90.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,962,000.00	4,112,500.00	-1,849,500.00	69.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	00.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	113.00	113.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	109.00	109.00	00.00	100.0

4.6. Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		119,328,079.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		119,328,079.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		119,328,079.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		40,220,978.00
210101	Үндсэн цалин		40,220,978.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,826,517.00
210201	Тэтгэврийн даатгал		4,826,517.00
2104	Хангамж, бараа материалын зардал		8,600,320.00
210401	Бичиг хэрэг		742,400.00
210402	Тээвэр, шатахуун		553,320.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,304,600.00
2105	Нормативт зардал		44,970,776.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		30,517,136.00
210502	Хоол, хүнс		14,453,640.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,057,588.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,179,988.00
210604	Урсгал засвар		1,877,600.00
2107	Томилолт, зочны зардал		567,000.00
210702	Дотоод албан томилолт		567,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		11,084,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		11,084,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		119,328,079.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		119,328,079.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,897,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		110,430,479.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Төсвийн шууд захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.25			САГ-2019/74/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Кассын үлдэгдэл байх естой үлдэгдлээс илүү дүнгээр үлдэгдэлтэй байна.	0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Батчимэг
2	Үйлдвэрлэлийн өртгийн тооцоолол хийж болохгүй, мөн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын орлого нь бөөн дүнгээр ерөнхий журналын бичилт хийгддэг.	0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г. Батчимэг
3	Суутган-1 тайлан дахь даатгуулагчаас төлсөн НДШ-ийн дүн Ниймийн даатгалын тайлангийн дүнгээс 6003875 зөрүүтэй. Татварын хөнгөлөлтийг илүү тооцсон	600.39	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Батчимэг
4	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар 99.2 мянган төгрөгийн нөхөн төлбөр, 49.6 мянган төгрөгийн алдангийг төлсөн	148.8	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Батчимэг
Дүн		749.19			